

## **Хүүхдийн Клиникийн сувилал №41**

Сонгино хайрхан дүүргийн Хүүхдийн Клиник сувилал №41 анх 1962 оны 10 дугаар сарын 12-энд дулааны 2 дугаар цахилгаан станцын ажилчдын 0-3 насны хүүхдийг авч асардаг ясли нэртэйгээр Улаанбаатар хотын АДХГЗ-ны тогтоолоор байгуулагдсан. Улаанбаатар хотын АДХГЗ-гаа, Эрүүл мэндийн сайдын 1991 оны А/39-83 дугаар тогтоолын 7-ын а дугаар заалтыг хэрэгжүүлэх, зорилгоор 1991 оны 09 дүгээр сарын 27-ний өдрийн Улаанбаатар хотын Эрүүлийг хамгаалах, Нийгэм хангамжийн газрын даргын 108 дугаар тушаалаар бие султай, суурь өвчтэй /сульдаа, тэжээлийн доройтолтой, шүүдэст эмзэг шил, цус багадалт, тархины гэмтэл/, архаг, олон дахин өвчилсөн өвчтэй хүүхдийг эмчлэх сувиллын ясли болгон өргөжүүлсэн.

Сувиллын ясли болж эрхлэгчээр хүүхдийн их эмчийг ажиллуулах болсон. 2001 оны 09 дүгээр сараас эхлэн Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох тухай Монгол Улсын Эрүүл мэндийн сайд Нийслэлийн Засаг даргын 2001 оны хамтарсан 98/197 дугаар тушаал, захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эрүүл мэндийн газрын даргын 2001 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 88 тоот тушаалаар Сонгино-хайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл, нутаг дэвсгэрийн Амбулатори, Нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлгээс илгээсэн архаг, суурь өвчтэй 5 хүртэлх насны хүүхдийг Монгол Улсын Эрүүл мэндийн багц хуулиуд, Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль бусад хууль тогтоомжуудын дагуу эмчилгээний хоол, эмийн бус эмчилгээн, байгалийн хүчин зүйлээр эмчлэх Хүүхдийн Клиник Сувилал болж үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

### **Одоогийн бүтэц зохион байгуулалт:**

Нийт 23 эмч ажиллагсадтай 3, тасагтай, 80 орны хүчин чадалтай байгууллага юм, Жилдээ 260-280 гаруй хүүхдийг хүлээн авч, 20 гаруй нэр төрлийн эмчилгээ сувилгаа хийж, 42 төрлийн эмчилгээний хоол, 10 гаруй төрлийн витаминьг эмчилгээний стандартын дагуу өгч үр дүнг нь тооцон ажиллаж байна.

2000-2001 оны 6 дугаар сар хүртэл "Хүүхдийн хоол тэжээлийн дутлаа сэргийлэх хөтөлбөр" сэдэвт ажлын хүрээнд Монгол дахь олон улсын Ротари байгууллага, Хоол судлалын төвтэй хамтарч хүүхдийн нэмэгдэл хоолны жижиг цех байгуулан ажиллалаа.

2002 оны 02 дугаар улиралд АДРА олон улсын байгууллагатай хамтарч Хүүхдийн эрүүл мэндийг дэмжих төслийн хүрээнд СХД-ийн 1,2,3,13, дугаар хорооны суурь өвчтэй 40 хүүхдийг эмчилж сувилж үр дүнг нь тооцоон ажиллаа.

2004-2005 онд Японы Осакагийн Их сургуулийн Нийгмийн Судлалын тэнхимийн багш нартай хамтарч СХД-ийн 1 хороонд хөдөөнөөс шилжиж ирсэн 60 өрхийн суурь өвчтэй хүүхдийг сувилж эмчилсэн.

СХД-ийн 21 хорооны хүүхдэд үйлчилгээ үзүүлж эмчилгээ сувилгаа явуулж байна.

Тус сувилал нь 2003 онд Нийслэлийн Эмнэлгийн тэргүүний байгууллага, 2003, 2006 онд Т Ашваагийн нэрэмжит уралдаанд тэргүүн байр эзэлсэн ажлын амжилттай ажиллаж ирлээ.

Сувиллын ерөнхий эмч Пунцаг овогтой Саранцэцэг, 1958 онд төрсөн 1978 оноос УБ Хотын АУДyC, 1987 онд АУДэс тус тус төгссөн. 1978-1981 онд Баянхонгор аймагт хүүхдийн тасаг сувилагч, 1987-1991 онд Баянхонгор аймгийн хүүхдийн эмнэлэгт хүүхдийн эмя 1991 оноос одоог хүртэл СХД-ийн Хүүхдийн Клиник Сувилал № 41 эрхлэгч, ерөнхий эмчээр ажиллаж байна.

Нийслэлийн Эмнэлгийн Тэргүүний ажилтан, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнагдсан.